ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Монголын Мэргэжлийн Боловсрол Сургалтын Төслийн Үнэлгээний Тайлан

1. Компакт гэрээний танилцуулга

Суурь мэдээлэл

Мянганы сорилтын корпораци (МСК) болон Монгол улсын засгийн газар (МУЗГ) хамтран 2008-2013 онд Монгол улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой Компакт гэрээг 5 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн. Нийт 284.9 сая ам.долларын санхүүжилт бүхий тус Компакт гэрээний хүрээнд хөрөнгийн эрх, эрүүл мэнд, мэргэжлийн боловсрол, эрчим хүч ба байгаль орчин болон зам тээврийн салбарыг хамарсан таван төсөл хэрэгжсэн. 2010 онд Компакт гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан төмөр замын төсөл хасагдсанаар санхүүжилт нь Мэргэжлийн боловсрол, сургалтын төсөл (МБСТ) болон бусад төслүүд рүү хуваарилагдсан билээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтын төсөл

Энэхүү тайланд Мэргэжлийн Боловсрол, Сургалтын төсөл /МБСТ/-ийн бодит үр дүнд суурилсан гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг танилцуулна. МБСТ нь дараах үндсэн таван үйл ажиллагааг хэрэгжүүлсэн:

1. ТМБС-ын бодлого, үйл ажиллагааны шинэчлэл
2. Ур чадварын стандарт болон чадамжид суурилсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх
3. Чадамжид суурилсан сургалтын (ЧСС) үйл ажиллагаа
4. Ажил, мэргэжлийг оновчтой сонгох, мэргэжлийн чиг баримжааны зөвлөгөө өгөх тогтолцоо, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх
5. Сургалтын орчинг сайжруулах (Компакт гэрээг шинэчлэх үеэр нэмсэн)

Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд дараах үндсэн дөрвөн зорилгод чиглэсэн олон ажлуудыг хийж гүйцэтгэсэн:

- ТМБС-ын чанарыг сайжруулах
- ТМБС-ыг ажил олгогчдын шаардлагад нийцүүлэх
- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх
- Орлогыг нэмэгдүүлэх

2. Үнэлгээний ажлын танилцуулга

МСК санхүүжүүлсэн төслийнхөө үр дүнг тайлагнахад чухал ач холбогдол өгч Компакт гэрээний дагуу хэрэгжүүлсэн төслүүддээ хараат бус, бие даасан үнэлгээ хийлгэдэг (МСС, 2017b). МСК нь МБСТ-ийн нөлөөллийн үнэлгээг хийлгэхээр "Ядуурлыг бууруулах санаачлага" (ЯБС) байгууллагатай гэрээлэн ажилласан боловч тус байгууллагын зүгээс төслийн хүрээнд *Сургалтын орчинг сайжруулах үйл ажиллагааны* чиглэлээр хийгдсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлд л нөлөөллийн үнэлгээ хийх боломжтой гэж тодорхойлсон.

Иймээс МСК МБСТ-ийн хүрээнд хэрэгжүүлсэн бусад үйл ажиллагааны үр дүнг хэмжих зорилгоор Социал Импакт Инк (СИ) байгууллагатай гэрээлэн МБСТ-д гүйцэтгэлийн үнэлгээг (ГҮ) хийлгэсэн. Гүйцэтгэлийн үнэлгээний эцсийн энэхүү тайланд төслийн хэрэгжилт, үнэлгээний загвар болон үр дүнгийн талаарх гол мэдээллийг хураангуйлан хүргэх болно. Энэхүү үнэлгээний ажлыг Социал Импакт байгууллагын төлөөлөн Доктор Кари Нэлсоны удирдсан баг бие даан гүйцэтгэсэн бөгөөд тус багийн гишүүд аливаа ашиг сонирхлын зөрчилгүй. Тайлангийн үр дүн судалгааны багийн гүйцэтгэсэн хараат бус үнэлгээнд суурилсан ба МСК болон АНУ-ын Засгийн газрын үзэл бодлыг төлөөлөхгүй.

Үнэлгээний асуултууд болон аргачлал

Үнэлгээний баг (ҮБ) Үнэлгээний менежментийн хороо (ҮМХ)-той хамтран боловсруулсан үнэлгээний явцад ашиглах 30 асуулт нь ТМБС-ын чанарыг дээшлүүлж, зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төгсөгчдийн ажил эрхлэлт болон орлогыг нэмэгдүүлэх гэсэн төслийн дөрвөн үндсэн зорилтыг үнэлэхэд чиглэсэн.

Үнэлгээний 30 асуултад хариулт авахын тулд ҮБ нь ярилцлага болон шууд ажиглалт хийхээс гадна ЗГ болон ЯБС-ын нөлөөллийн үнэлгээний тайлангаас авсан хоёрдогч эх үүсвэрийн өгөгдлийг ашиглах холимог үнэлгээний аргачлалыг боловсруулсан. Хүснэгт 1-д үнэлгээний асуултууд болон аргачлалыг хураангуйлан үзүүлэв.

Хүснэгт 1: Үнэлгээний асуултын хураангуй

МБСТ-ийн үр нөлөө	Үнэлгээний асуултын тоо	Чанарын мэдээлэл цуглуулсан аргачлал	Тоон мэдээлэл цуглуулсан аргачлал
МБСТ-ийн хэрэгжилт	2	- Ярилцлага - Бичиг баримтаас судлах	
Зорилт 1: Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх	4	- Ярилцлага	- Хоёрдогч өгөгдөл
Зорилт 2: Орлогыг нэмэгдүүлэх	3	- Ярилцлага	- Хоёрдогч өгөгдөл
Үр нөлөө 1: ТМБС-ын тогтолцооны чанарыг сайжруулах	12	- Ярилцлага - Ажиглалт	- Хоёрдогч өгөгдөл
Үр нөлөө 2: ТМБС-ын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад илүү нийцүүлэх	7	- Ярилцлага - Ажиглалт	
Бусад үр нөлөө (ТМБС элсэлт)	2	- Ярилцлага	- Хоёрдогч өгөгдөл

3. Төсөл хэрэгжсэн байдал

МБСТ олон үйл ажиллагаа бүхий бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдсэн ба доорх хүснэгтэд таван гол бүрэлдэхүүн хэсгийн үндсэн зорилго болоод тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хамтаар жагсаан харуулав (СИ байгууллагын Үнэлгээний загварын тайланд төслөөс хэрэгжүүлсэн үйл ажиллагаа бүрийг дэлгэрэнгүй жагсаан оруулсан ба доорх хүснэгтэд зөвхөн гол хэсгүүдийг багтаасан болно).

Хүснэгт 2: МБСТ-ийн үйл ажиллагаа

МБСТ-ийн үйл ажиллагаа	Зорилго (Компакт гэрээний нэмэлт өөрчлөлтөд тусгаснаар)	Гол үйл ажиллагаа
1. Техник мэргэжлийн боловсрол сургалтын (ТМБС) бодлого үйл ажиллагааны шинэчлэл хийх үйл ажиллагаа	ТМБС-ын салбарт хувийн хэвшлийн оролцоог хангах, үр дүнтэй засаглал болон тогтолцоог бий болгох, салбарын бодлого, үйл ажиллагааг сайжруулж бэхжүүлэх.	• Төр хувийн хэвшлийн түншлэлийг идэвхжүүлэх өрсөлдөөнт тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх • Хууль эрх зүйн шинэчлэлийг дэмжих • Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийг байгуулах (МБСҮЗ) • ТМБС-ын байгууллагуудын удирдлага, багш нарын чадавхийг бэхжүүлэх • ТМБС-ыг олон нийтэд таниулах кампанит ажил зохион байгуулах
***2.* Ур чадварын стандарт чадамжид суурилсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх үйл ажиллагаа**	Ур чадвар болон мэргэжлийн нэгдсэн стандартуудыг тогтоон чадамжид суурилсан сургалтын тогтолцоог бий болгон нэвтрүүлж хэрэгжүүлэх.	• Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, материалыг боловсруулах • Мэргэжлийн боловсрол, сургалт судалгааны төвийг байгуулах • Мэргэжлийн түвшний үндэсний хүрээ (МТҮХ), чадамжийн стандартуудыг боловсруулах • Мэдээлэл арга зүйн үндэсний төвийг (МАЗҮТ) байгуулах
3. Чадамжид суурилсан сургалтын (ЧСС) тогтолцооны үйл ажиллагаа	ЧСС тогтолцоог хэрэгжүүлэх буюу үүнд чадамжид суурилсанүнэлгээний стандартыг ТМБС-ын байгууллагууд, коллеж, сургалтын төвүүдэд нэвтрүүлэх.	• Гол мэргэжлийн багш нарыг сургах, техникийн англи хэлний сургалт болон бусад чиглэлийн сургалтад хамруулах • Багш нарыг олон улсын стандартад нийцүүлэн гэрчилгээжүүлэх • Ажлын байранд дадлага хийлгэх туршилтын хөтөлбөрийг боловсруулах
4. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоог (ХЗЗМТ) бий болгох үйл ажиллагаа	ХЗЗМТ-г бий болгоход дэмжлэг үзүүлэх, мэдээллийн технологийн тоног төхөөрөмж холбогдох програм хангамжийг нийлүүлэх. Мөн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох-зөвлөгөө өгөх, ажлын байрны талаар мэдээлэл олгох үйлчилгээ нэвтрүүлэх.	• ХЗЗМТ хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийх • ХЗЗМТ –г хөгжүүлэх • Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох тогтолцоог хөгжүүлэх, зөвлөгөө өгөх сургагч багш нарыг бэлтгэх
5. Сургалтын орчинг сайжруулах үйл ажиллагаа	Сонгогдсон 15 сургалтын байгууллагын засвар, анги танхимыг шинэчлэх, тэдгээрээс 3 сургуулийг жишиг сургууль болгох.	• Гурван жишиг сургуулийг оролцуулаад нийт 17 сургуулийн барилгын засвар, анги танхим тохижуулах • ТМБС-ын хөтөлбөрүүдэд зориулан орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах

4. Үр дүн

Үнэлгээний 30 асуултын хариуг хэрэгжилтийн үр нөлөө ба ТМБС-ын чанар, хөдөлмөрийн зах зээлийн нийцэл, элсэлт, ажил эрхлэлт болон орлогод үзүүлсэн нөлөө гэсэн зургаан гол бүлэгт багцлан доор хураангуйлан үзүүлэв. Бүлэг бүрийн эхэнд ерөнхий танилцуулга, доор нь үнэлгээний асуулт бүрийн хариултыг хүснэгтэд оруулан дэлгэрэнгүй тайлбарласан болно.

Хэрэгжилтийн үр ашиг

2010 онд Компакт гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан төсвийг бараг хоёр дахин нэмэгдүүлснээр *Сургалтын орчинг сайжруулах* гэсэн тав дахь бүрэлдэхүүн хэсгийг нэмсэн ньтөсөл хэрэгжүүлэх явцад хийсэн гол өөрчлөлт байв. Уг өөрчлөлтийг оролцогч талууд эерэгээр хүлээж авсан ба төсөл хэрэгжүүлэгч нэгжийн ажилтнууд чадвартай, ТМБС дахь оролцогч талуудтай хамтын ажиллагаа сайн байсан боловч төсөл хэрэгжүүлэх явцад хэд хэдэн гадаад болон дотоод хүчин зүйлс бэрхшээл учруулж байв. Тулгарсан гол хүндрэл нь ЗГ-ын шийдвэртэй холбоотой улс төрийн тогтворгүй байдал болон хэт амбицтай олон бүрэлдэхүүн хэсэг бүхий төслийн загвар зэрэг байжээ.

Хүснэгт 3: Хэрэгжилт–Гол үр дүн

Үнэлгээний асуулт	Гол үр дүн
1. МБС төсөл нь хэр зэрэг анхны төлөвлөлт, үндэслэлийн хүрээнд хэрэгжсэн бэ?	Компакт гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтөөс бусдаар МБСТ анхны төлөвлөлтийн дагуу хэрэгжсэн ба үр ашгийгнэмэгдүүлэхзорилгоор төслийн зарим үйл ажиллагаанд бага зэрэг өөрчлөлт оруулах тохиолдол байсан.
2. Төслийг хэрэгжүүлэхэд ямар ахиц дэвшил, үр дүн гарсан бэ? Ямар томоохон хүндрэл бэрхшээл тулгарсан бэ?	Гарсан ахиц дэвшил, үр дүн: • Ур чадвартай ажилтнууд • Оролцогч талуудын хамтын ажиллагаа • ТХН, МСК болон Мянганы Сорилтын Сан (МСС) хоорондын дотоод харилцаа, хамтын ажиллагаа сайн • Төслийн уян хатан байдал Тулгарсан хүндрэл бэрхшээл: • Улс төрийн сорилтууд/нөлөө • Төслийг хэрэгжүүлэхэд төвөгтэй, өргөн цар хүрээг хамарсан • Улс орны нөхцөл байдалд сайн тохируулаагүй • Ажилтнуудын салбарын мэдлэг, чадвар дутмаг • Үйл ажиллагаа хоорондын уялдаа холбоо сул

ТМБС-ын чанарт үзүүлсэн нөлөө

ТМБС-ын чанар төсөл хэрэгжиж эхлэхээс өмнөх үеийнхтэй харьцуулахад үлэмж сайжирсан гэдгийг оролцогч талууд санал нэгтэйгээр хүлээн зөвшөөрсөн ба уг өөрчлөлтөд МБСТ голлох үүргийг гүйцэтгэсэн гэж үзэж байна. Гэхдээ Мэдээлэл арга зүйн үндэсний төв (МАЗҮТ) болон Жишиг сургууль зэрэг чанарыг сайжруулах зорилгоор хийгдсэн ажлууд бүгд тогтвортой үр дүнд хүрээгүй буюу анхны зорилтот үүргийнхээ дагуу үйл ажиллагаа явуулахгүй байна. Харин ЧСС-ын хөтөлбөрийг нэвтрүүлэн хэрэгжүүлсэн, сургалтын орчинг сайжруулсан болон тоног төхөөрөмжөөр хангасан зэрэг төслийн үйл ажиллагааг дийлэнх нь сайшаажээ (зарим хүндрэл бэрхшээлийг үл харгалзан).

Хүснэгт 4: ТМБС-ын чанар–Гол үр дүн

Үнэлгээний асуулт	Гол үр дүн
3. Компакт гэрээ дуусгавар болсноос хойш ТМБС-ын байгууллага, жишиг сургуулиудад хийгдсэн барилга засвар, шинэчлэлтийн ажлын ашиглалт, засвар үйлчилгээ хэр зэрэг хийгдэж ирсэн бэ? Яагаад/Үгүй бол яагаад?	Төслийн хүрээнд тохижуулсан анги танхим, дадлагын өрөөнүүдийн засвар үйлчилгээ ерөнхийдөө сайн хийгдсэн. Гэхдээ засвар үйлчилгээний зардлын санхүүжилт хүндрэлтэй байснаас ихэнхдээ сургуулийн ажилтнууд болон оюутнууд уг ажлыг хийж гүйцэтгэх хандлагатай байна.
4. Компакт гэрээ дуусгавар болсноос хойш МБС-ын төслийн хүрээнд нийлүүлсэн сургалтын тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ хэр зэрэг хийгдсэн бэ? Яагаад/Үгүй бол яагаад?	Тоног төхөөрөмж хэвийн ажиллаж буй сургуулиуд тэдгээрийг бүрэн ашигласан, засвар үйлчилгээг өөрсдийн боломжоороо тогтмол сайн хийсэн нь ажиглагдсан. Дараах хүндрэл бэрхшээлүүдийг нэрлэсэн нь: • Засвар үйлчилгээтэй холбоотой асуудал (эд анги болон лиценз) • Тоног төхөөрөмж хоцрогдсон • Тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангалтгүй • Хангалттай хэмжээнд сургалт явуулаагүй • Нийлүүлсэн тоног төхөөрөмж чанарын шаардлага хангаагүй
5. Мэргэжлийн түвшний үндэсний хүрээ (МТҮХ) болон холбогдох ур чадварын стандартууд өнөөдөр ямар түвшинд байгаа вэ? ТМБС-ын хөтөлбөрүүд болон суралцагчид/төгсөгчид тэдгээрийг хэр зэрэг ашигладаг вэ? Гэрчилгээжүүлэлтэд ач холбогдол, үнэ цэнэ өгдөг үү?	Компакт гэрээ дуусгавар болох үед МТҮХ-г боловсруулан батлуулсан боловч хараахан хэрэгжүүлж амжаагүй байсан. МТҮХ албан ёсоор хэрэгжиж эхлэх хүртэл бусад донор байгууллагууд уг ажлыг үргэлжлүүлсэн. Оролцогч талууд (багш нар, сурагчид болон хувийн хэвшлийн төлөөлөл) МТҮХ-ний талаар мэдээлэл хомс, огт мэдэхгүй байх тохиолдолд олон байсан нь үүнийг бүрэн нэвтрүүлж, хэрэглэж занших хүртэл хийгдэх ажил их буйг илтгэж байна. Гэрчилгээ нь хөтөлбөр дүүргэснийг илтгэх батламж гэдэг утгаараа үнэ цэнэтэй боловч төгсөгчдийн ур чадварыг илтгэх хэмжээнд бүрэн үнэлэгдэхгүй байна. Зарим тохиолдолд бусад стандарт, гэрчилгээнүүд илүү үнэлэгдэж байна.
6. Мэргэжлийн түвшний үндэсний хүрээний өөрчлөлтүүд ТМБС-ын тогтолцоо, ерөнхий чиг үүрэг, үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлсөн бэ?	МТҮХ салбарын хэмжээнд нэгдсэн стандарт тогтоож, харьцуулалт хийх түвшинг тодорхойлж өгсөн.
7. МБС төслөөс боловсруулсан чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрүүдийг (ЧССХ) улсын хэмжээнд ТМБС-н байгууллагууд сургалтын практиктаа хэр зэрэг бүрэн дүүрэн нэвтрүүлж, хэрэгжүүлсэн бэ?	МБСТ эхлүүлэн бусад донор байгууллагууд үргэлжлүүлэн хэрэгжүүлсний үр дүнд ЧСС өргөн ашиглагдаж байна. Цаашид олон ажил хийгдэх шаардлагатай ч салбартаа нэгдсэн ойлголттой болоод зогсохгүй хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэн, дадлагын сургалтыг чухалчлах шилжилтийн зам руугаа орсон байна.
8. ЧСС-ын хөтөлбөрийг үр дүнтэй нэвтрүүлэн хэрэгжүүлэхэд ямар хүчин зүйлс эерэг болон/эсхүл сөргөөр нөлөөлсөн бэ?	Эерэгээр нөлөөлсөн хүчин зүйлс: • Суралцагчдын сурах үйл явцад ЧСС-ийн үр өгөөж илэрч байгаа • Сургалт (багш нар, сургуулийн захиргаа болон бусад холбогдох ажилтнуудад) • Хөтөлбөр боловсруулахад багш нарын оролцоог хангасан • Төрөөс ЧСС хөтөлбөрт шилжих шаардлага тавьсан • Тоног төхөөрөмжөөр ханган дадлага хийх бололцоог бүрдүүлсэн Тулгарсан гол хүндрэл бэрхшээлүүд:

	• Нөөц бололцоо хангалтгүй (ялангуяа тоног төхөөрөмж, барилгын засвар үйлчилгээнд зориулсан) • Хуучин арга барил/хандлагыг өөрчлөхөд төвөгтэй • Бичиг цаасны ажил их • Нэгдсэн стандарт хөтөлбөр байхгүй • Ойр ойрхон шинэчилж өөрчилсөн нь ажлын ачааллыг нэмэгдүүлсэн • Хувийн хэвшлийн оролцоо хангалтгүй
9. Компакт гэрээ дуусгавар болсноос хойш ТМБС-ын салбар чадамжид суурилсан сургалтын материалуудаа хэр зэрэг сайжруулсан, эсвэл шинэчлэн боловсруулсан бэ?	Компакт гэрээ дуусгавар болсноос хойш ЧССХ-ийг шинэчлэн сайжруулсан ба энэ нь хөтөлбөрийн чанарт дараах байдлаар нөлөөлсөн гэж оролцогчид дүгнэсэн: • Чанарыг сайжруулсан • Шинэ мэргэжлүүд нэмэгдсэн
10. Мэдээлэл, арга зүйн үндэсний төв (МАЗҮТ) болон бүсийн арга зүйн төвүүдийн үйлчилгээг (БАЗТ) ТМБС-н байгууллага, багш/ажилтнууд хэр зэрэг ашигладаг вэ?	2012 оноос улс төрийн бодлого, тэргүүлэх чиглэлд өөрчлөлт орж Засгийн газар солигдсоны дараа МАЗҮТ-ийг санхүүжүүлэх байгууллага, хууль эрх зүйн байдал тодорхойгүй болсон тул өдгөө үйл ажиллагаа явуулахгүй байна. БАЗТ-үүд үйл ажиллагаа явуулж ТМБС-ын тогтолцоонд тодорхой үүргийг гүйцэтгэж байгаа боловч анх байгуулагдсан зорилтууддаа хүрэх хэмжээнд ажиллаж чадахгүй байгаа нь бүтэц, зохион байгуулалттай нь холбогдон үүссэн хэд хэдэн хүндрэл бэрхшээлээс улбаатай.
11. Жишиг сургуулиуд (CoEs) бусдад үлгэр дуурайл болох чиг үүргээ хэр зэрэг биелүүлж байна вэ? Яагаад /Үгүй бол яагаад?	Жишиг сургуулиуд хэвийн үйл ажиллагаа явуулж буй боловч өндөр чанартай ТМБС-ын туршлагыг түгээн дэлгэрүүлэх гэсэн үндсэн үүргээ гүйцэтгэхгүй байна.
12. Суралцагчид, төгсөгчид, багш нар сургалтын хөтөлбөр, материалын чанарыг хэр зэрэг өндөр түвшинд авч үздэг вэ?	Хувийн хэвшлийн төлөөлөлтэй харьцуулахад багш нар, суралцагчид болон төгсөгчид илүү өндрөөр үнэлж байна.
13. Төсөл эхэлснээс хойш сургалтын чанар хэр зэрэг дээшилсэн бэ?	МБСТ хэрэгжиж эхэлснээс хойш ТМБС-ын чанар эрс дээшилснийг оролцогч талуудын дийлэнх олонх нь хүлээн зөвшөөрч байна. Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйлс нь: • Сургалтын орчин тоног төхөөрөмж сайжирсан • МБСТ • Дадлагын сургалтын цагийг ихэсгэсэн явдал
14. МБС-ын төслөөс сургалтын чанарыг сайжруулах зорилгоор боловсруулсан материал, сургалтыг бусад ТМБС-ын байгууллагууд хэр зэрэг ашигласан бэ?	Бараг бүх оролцогч тал МБСТ-ийн үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэлтэй байсан. Дээр өгүүлсэнчлэн чанарын өөрчлөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйлсийн нэг нь сургалтын орчин, тоног төхөөрөмжийг сайжруулсан явдал (ихэвчлэн МБСТ-өөс), мөн түүнчлэн МБСТ, түүний хүрээнд явуулсан сургалтууд гэж үзэж байна.

ТМБС-ыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцүүлэхэд үзүүлсэн нөлөө

ТМБС-ын чанарыг үнэлсэнтэй нэгэн адилаар ТМБС-ын салбар болоод хувийн хэвшил олон талаар хамтран ажиллах нь төсөл эхэлснээс хойш ихээхэн сайжирсан гэж оролцогч талууд үзэж байна. Гэвч хамтын ажиллагаа үндэсний буюу дээд түвшинд гэхээсээ илүү орон нутгийн түвшинд илүү идэвхтэй байна. 2012 онд засаг солигдсоны дараа Мэргэжлийн боловсрол сургалт хариуцсан агентлаг татан буугдсанаар МБСҮЗ олгогдсон эрх үүргийнхээ дагуу үйл ажиллагаа явуулах эрх нь хязгаарлагдсан байна.

Хүснэгт 5: ТМБС-ын нийцэл–Гол үр дүн

Үнэлгээний асуулт	Гол үр дүн
15. ТМБС-ын салбар дахь хувийн хэвшлийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжихэд МБС-ын Үндэсний Зөвлөл болон Засгийн газрын хэрэгжүүлэх агентлаг - Мэргэжлийн Боловсрол Сургалтын Газар (МБСГ) ямар үр нөлөө үзүүлсэн бэ? МБСГ татан буугдсаны дараа юу тохиолдсон бэ? Энэ нь хувийн хэвшлийн идэвх, оролцоонд ямар үр нөлөө үзүүлсэн бэ?	МБС-ын Үндэсний зөвлөл болон МБСГ-ыг байгуулснаар хувийн хэвшлийн төлөөллийг ТМБС-ын салбар дахь шийдвэр гаргах дээд түвшинд оролцох бололцоог бүрдүүлэн, төслийн эхэн үед анхаарлыг нь татаж чадсан боловч 2012 оны сонгуулийн дараа уг агентлагийг татан буулгаж яамны хэлтэс болгосноор МБСҮЗ-ийн үйл ажиллагаанд идэвхтэй дэмжлэг үзүүлэх чадамж нь буурсан. Түүнээс хойш хувийн хэвшлийн оролцоо орон нутгийн түвшинд тодорхой хэмжээнд идэвхтэй, харин үндэсний буюу дээд түвшинд сул байна.
16. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоо (ХЗЗМТ) болон мэргэжлийн чиг баримжаа олгох-зөвлөгөө өгөх тогтолцооны вебсайтууд өдгөө ажиллаж байгаа юу? Яагаад/Үгүй бол яагаад?	2012 онд төр, засаг солигдож, тогтолцоог удирдах дээд байгууллага өөрчлөгдсөнөөр үйл ажиллагаа нь суларч ХЗЗМТ болон мэргэжлийн чиг баримжаа олгох-зөвлөгөө өгөх вэбсайт Компакт гэрээ дуусаны дараахнаас ажиллахаа больсон.
17. Компакт гэрээ дуусгавар болсноос хойш ХЗЗМТ болон мэргэжлийн чиг баримжаа олгох-зөвлөгөө өгөх тогтолцооны вебсайтуудын агуулга (контент) хэр зэрэг шинэчлэгдсэн/сайжирсан бэ?	Хэдийгээр ХЗЗМТ болон мэргэжлийн чиг баримжаа олгох-зөвлөгөө өгөг тогтолцооны вэбсайтууд хаагдсан ч бусад донор байгууллагууд мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх тогтолцоог бий болгох шаардлага буйг анзаарч шинэ цахим систем үүсгэх ажлууд хийгдсэн.
18. Төслийн үр дүнд МБС-н салбар дахь хувийн хэвшлийнролцоо, хамтын ажиллагаа, үр нөлөө хэр зэрэг сайжирсан бэ?	МБСТ эхэлснээс хойш хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж, ТМБС-ын байгууллагууд болон хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагаа гүнзгийрэн,орон нутгийн түвшинд ч олон хэлбэрээр хамтарч ажиллах болсон гэдэгтэй дийлэнх оролцогчид санал нэгдэж байна. Гэхдээ төсөл эхлэхээс өмнө хамтын ажиллагаа бараг байгаагүй тул хувийн хэвшлийн оролцоо зохистой түвшинд хүрэх болоогүй байна. Том компаниудтай хамтран ажиллахад бодлогын хэрэгжилттэй холбоотой бэрхшээлүүд тулгарч байна.
19. МБС төсөл дуусснаас хойш ЧСС-ийн хөтөлбөрийг сайжруулах ажил хэр зэрэг хийгдсэн бэ? Яагаад/үгүй бол яагаад?	Сургуулиудын зүгээс хөтөлбөрөө сайжруулахдаа хувийн хэвшлийн оролцоог хангахыг эрмэлздэг ба ажил олгогчдын санал зөвлөмж, шинээр гарч буй технологийг хөтөлбөртөө тусгах байдлаар сайжруулалт хийдэг. Хувийн хэвшлийнхэн төгсөгчдийн ур чадвар дээшилж буйг анзаарч байгаа боловч үүнийг хөтөлбөрт өөрчлөлт орж буйтай холбож авч үзэхгүй байна.
20. ТМБС-ын салбар дахь хувийн хэвшлийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжсэн ба/эсвэл сааруулсан ямар гол хүчин зүйлс байсан бэ?	Хамтын ажиллагаа нэмэгдэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл нь ТМБС-ын байгууллагууд болон бизнесийн түншүүд аль аль талаасаа түншлэлийн ач холбогдлыг ойлгосон явдал байв. Том компаниудын оролцоо сул, орон нутгийн жижиг бизнесүүдийн зүгээс дэмжлэг үзүүлэх боломж хязгаарлагдмал зэрэг бэрхшээл голлон тулгарч байна.
21. Компакт гэрээ дуусгавар болсноос хойш ТМБС-н байгууллагуудын зүгээс төр, хувийн хэвшлийн түншлэлд хэр зэрэг оролцож хамтран ажиллаж байгаа вэ? Яагаад?/Үгүй бол яагаад?	Хамтран ажилладаг хувийн хэвшлийн зүгээс сургуулиудад шууд хөрөнгө оруулалт хийсэн, хамтарсан төсөл хэрэгжүүлсэн тохиолдол маш цөөн байна. Сургуульд хөрөнгө оруулахтай холбоогүй бусад төрлийн хамтын ажиллагаанд үндэслэн сургуулиуд төр, хувийн хэвшлийн түншлэлд сайн оролцож байна гэж үзэж байна. Орон нутгийн түвшинд бусад төрлийн хамтын ажиллагаа идэвхтэй байгаа ч сургуулиудын санхүүгийн эх үүсвэрийг өргөтгөх гэсэн МСК-ийн зорилт руу чиглэхгүй байна. Уг салбарт хувийн хэвшлийн зүгээс сургуулиудад хөрөнгө оруулахад тулгарч буй гол бэрхшээл нь санхүүжилттэй

	холбоотой бодлого, хууль журам тодорхойгүй байгаа явдал юм.
22. ТМБС-ын байгууллагууд ажил олгогчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн ур чадварыг суралцагчдад хэр зэрэг эзэмшүүлж чаддаг гэж хувийн хэвшлийн оролцогч талууд дүгнэдэг вэ? Энэ нөхцөл байдал Компакт гэрээ хэрэгжсэн цагаас хойш хэр зэрэг өөрчлөгдсөн бэ?	Ажил олгогчдын зүгээс ТМБС-ын чанар дээшилсэн, мөн тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн ур чадварыг буюу ялангуяа техникийн ур чадварыг суралцагчдад сайн эзэмшүүлдэг болсон гэж дүгнэсэн. Уг эерэг өөрчлөлт нь ЧССХ-ийн шаардлагыг дагаад дадлагын сургалтын цагийг ихэсгэсэнтэй холбоотой. Нөгөө талаар төгсөгчдийн хандлага, төлөвшил сул байгаа нь ТМБС-ын байгууллагуудын гол анхаарах асуудал болохоос гадна ажил олгогчдод тулгарч буй том бэрхшээл болоод байна.

Элсэлт болон төгсөлтөд нөлөөлсөн байдал

2012–2013 онд ТМБС-ын байгууллагад элсэгчдийн тоо дээд цэгтээ хүрээд түүнээс хойш буурсан үзүүлэлттэй байна. Нийт элсэгчдийн тоо буурсан боловч төгсөгчдийн тоо жил бүр өссөөр Компакт гэрээ хэрэгжиж эхлэхээс өмнөх үеийнхтэй харьцуулахад одоогийн байдлаар 38 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6: Элсэлт–Гол үр дүн

Үнэлгээний асуулт	Гол үр дүн
23. ТМБС-ын байгууллагуудын элсэлт хэр зэрэг нэмэгдсэн бэ?	ТМБ сургуулиудын элсэлт сүүлийн хэдэн жил буурсан боловч нийт төгсөгчдийн тоо төсөл эхлэхээс өмнөх үеийн түвшингээс дээгүүр байв. Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйлс нь суралцагчдад олгодог тэтгэмж (эсвэл зогссон) болон ТМБС-ын салбарыг үнэлэх үнэлэмж байна. Элсэлт буурсныг үл харгалзан төгсөгчдийн тоо аажмаар өссөн үзүүлэлттэй байна.

Ажил эрхлэлтэд нөлөөлсөн байдал

Төгсөгчдийн ажил эрхлэлтэд үзүүлсэн МБСТ-ийн урт хугацааны нөлөөлөл тодорхойгүй. Ярилцлагад оролцогчид ажил эрхлэлтийн түвшин нэмэгдсэн гэж үзэн, судалгаанд хамруулсан сургуулиудаас өгсөн мэдээнд ажил эрхлэлтийн түвшин өссөн гэж харуулсан боловч үндэсний статистикийн мэдээнд төгсөгчдийн ажил эрхлэлт буурч байгаа гэжээ.

Хүснэгт 7: Ажил эрхлэлт–Гол үр дүн

Үнэлгээний асуулт	Гол үр дүн
24. Төсөл эхэлснээс хойш ТМБС-ын байгууллагыг төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ?	Ажил эрхлэлтийн хувьд мэдээлэл зөрүүтэй байна. Ярилцлагад оролцогчид төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин өндөр байгаа гэж хариулсан боловч үндэсний статистикийн мэдээнээс харахад ажил эрхлэлтийн түвшин мэдэгдэхүйц буурсан үзүүлэлттэй байна. Өгөгдөл тодорхойгүй, мөн ажил эрхлэлтийн түвшинд нөлөөлж буй олон гадаад хүчин зүйлс буйг харгалзан үзээд одоогийн байгаа мэдээлэл дээр үндэслэн төслийн зүгээс төгсөгчдийн ажил эрхлэлтэд нөлөөлсөн эсэхийг тодорхойлох боломжгүй байна.
25. Суралцагчид болон төгсөгчдийн ажилд шалгарч орох чадвартнөлөөлсөн хамгийн гол хүчин зүйл юу байсан бэ?	Доор жагсаасан хүчин зүйлсээс хамааraад ажил эрхлэлтийн түвшин хэлбэлзэж байв. Тухайн нөхцөл байдлаас хамааraад хүчин зүйл тус бүр эерэг эсхүл сөргөөр нөлөөлсөн байж болно. Гол хүчин зүйлс: • Төгсөгчдийн ур чадвар (хувийн хэвшлийнхний онцолсноор) • Эдийн засгийн ерөнхий байдал • Сургуулийн чанар • Их дээд сургуульд үргэлжлүүлэн суралцах явдал • Дадлага сургалт

	• Гэр бүлийн нөлөө • Төгсөгчдийн нас • Сургуулиуд ажил олгогчидтой хамтран ажиллах байдал • Хүйсийн ялгаа
26.Суралцагчид ажил мэргэжлийн шийдвэр гаргахдаа ажил мэргэжлийн чиг баримжаа олгодог зөвлөх мэргэжилтнүүдэд хэр зэрэг ханддаг эсвэл цахим тогтолцоог хэр зэрэг ашигладаг вэ? Тэдний ажилд орох чадварт тэдгээр нөөц боломж хэр зэрэг үр нөлөөтэй үзүүлдэг вэ? Яагаад/үгүй бол яагаад?	Сургуулиудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох-зөвлөгөө өгөх үйлчилгээ тодорхой хэмжээнд байгаа ба төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө уг үйлчилгээ сургуулиудад бараг байгаагүй буюу маш хязгаарлагдмал байв. Гэхдээ бусад донор байгууллагууд МБСТ-тэй харьцуулахад энэ чиглэлээр илүү өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулжээ. Үйлчилгээний хамрах хүрээ хязгаарлагдмал байснаас шалтгаалан ашиг тус нь төдийлөн илрээгүй. Суралцагчид багш нар, дадлагын газар болоод танилын хүрээллээрээ дамжуулан ажилд орох нь элбэг байна.
27. Монгол улс дахь хөдөлмөр эрхлэлтийн түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ?	2008 – 2018 оны хооронд үндэсний хэмжээнд ажил эрхлэлтийн түвшинд өөрчлөлт ороогүй ба энэ нь олон хүчин зүйлсээс хамааралтай.

Орлогод нөлөөлсөн байдал

МБСТ-ийн орлогод нөлөөлсөн байдал тодорхойгүй. Ярилцлагад оролцогчдын дийлэнх нь орлого өсч байгаа гэж хариулсан боловч үүнд төсөл хэрхэн нөлөөлснийг бусад хүчин зүйлс болох эдийн засгийн ерөнхий байдал, байгууллагуудын цалин хөлсийг үе шаттай нэмэгдүүлэх дотоод бодлого зэргээс салгаж дүгнэх нь ярвигтай.

Үнэлгээний асуулт	Гол үр дүн
28. Төсөл хэрэгжсэнээс хойш ТМБС-ын байгууллагыг төгсөгчдийн орлого хэр зэрэг нэмэгдсэн бэ?	Үр дүн тодорхойгүй. Ярилцлагад оролцогчид төгсөгчдийн орлого нэмэгдэж байгаа гэж хариулсан боловч хэд хэдэн хувьсагчаас харахад орлого өссөнийг батлах боломжгүй болж байна.
29. ТМБС-н байгууллагын суралцагч болон төгсөгчдийн ажил хөдөлмөр эрхэлж олсон орлого өөрчлөгдөхөд хамгийн их нөлөөлсөн хүчин зүйл юу байсан бэ?	Орлого ерөнхийдөө өссөн үзүүлэлт харагдаж байгаа нь тухайн цаг үеийн нөхцөл байдлаас хамаарсан олон хүчин зүйлтэй холбоотой. Гол хүчин зүйлс: • Төгсөгчдийн ур чадвар • Эдийн засгийн ерөнхий байдал • Мэргэжлээс хамаараад орлогын хэмжээ ялгаатай • Байгууллагын дотоод журмаас хамааараад тодорхой хугацаанд ажилласны дараа цалин нэмэгддэг • Хүйсийн ялгаа
30. Төсөл эхэлснээс хойш ажилгүй болон тогтмол ажил эрхэлдэггүй иргэдийн орлого хэр зэрэг өөрчлөгдсөн бэ?	Нэг хүнд ногдох ҮНО 2013 оноос хойш буурсаар ирсэн боловч төсөл эхлэхээс өмнөх үеийнхтэй харьцуулахад өндөр байна. ҮНО-ыг худалдан авах чадварын паритетаар засварлагдсан утгаас харахад огцом өсөлттэй байна. Үндэсний статистикийн мэдээг ашиглан өмнө нь ажилгүй байсан болон тогтмол ажил эрхэлдэггүй иргэдийн орлогыг тооцох боломжгүй байна.

5. Дүгнэлт

МБСТ нь хамрах цар хүрээ, хийж гүйцэтгэх ажлууд болоод хүрэхийг зорьсон зорилтуудынхаа хувьд амбицтай төсөл байв. МБСТ нь Монгол Улсын хоцрогдмол, хэт төвлөрсөн, зах зээлийн эрэлттэйгээ нийцээгүй, хүмүүс тэр болгон сонгон суралцдаггүй салбарын нэр хүндийг өсгөж, өндөр чанартай техник мэргэжлийн боловсрол олгодог салбар болгох зорилготой байв. Компакт гэрээнд тусгасны дагуу МБСТ-ийн зорилго нь ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлж ажилгүй монгол иргэдэд ур чадвар эзэмшүүлэн ажил

орлоготой болгох явдал байв. Уг зорилгын биелэлттэй холбоотой үр дүнг ТМБС системийн нийцэл, чанарын ахицаар тодорхойлохдоо санхүүгийн тогтвортой байдал (ТМБС-д хийгдсэн төрийн бус санхүүжилтийн хэмжээгээр), элсэлтийн түвшин болоод төгсөгчдийн ажил эрхлэлт, орлогыг хэмжсэн индикаторуудаар харууллаа.

МБСТ зорьсон зорилтуудаа 100 хувь амжилттай биелүүлж чадаагүй. Төслийн зүгээс төгсөгчдийн ажил эрхлэлт, орлогод үзүүлсэн нөлөө тодорхойгүй, мөн ТМБС-ийн элсэлт МСК-аас хүлээсэн хэмжээнд нэмэгдээгүй. Үүнд нөлөөлсөн хүчин зүйлсийн нэг нь 2012 оны сонгуулиас хойш эхэлсэн улс төрийн тогтворгүй байдал ба энэ нь эерэг өөрчлөлтөд тэмүүлсэн хурдыг сааруулж ТМБС-ын оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх хүрээнд хийгдсэн ажлуудын үр нөлөөг бууруулжээ. Мөн түүнчлэн хэрэгжилттэй холбоотой тулгарсан бэрхшээлүүд, глобал эдийн засгийн хүчин зүйлс болоод төслийн ярвигтай байдал нь үр дүнд нөлөөлсөн буюу МБСТ-ийн нөлөөллийг илрүүлэхэд хүндрэл учруулсан. МАЗҮТ болон ХЗЗМТ ба ажил мэргэжлийн чиг баримжаа олгох-зөвлөгөө өгөх тогтолцооны вэбсайт зэрэг хэд хэдэн бүрэлдэхүүн хэсэг Компакт гэрээ дуусгавар болох үед эсхүл дуусаны дараахнаас ажиллахаа больсон. Хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх (хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн), Бүсийн арга зүйн төвүүдийн (БАЗТ) үйл ажиллагааг бэхжүүлэх болон жишиг сургуулиудыг байгуулан сайн туршлагыг түгээх зэрэг зорилтууд тодорхой хэмжээнд амжилттай үр дүнд хүрсэн.

МБСТ-ийг хэрэгжүүлэх явцад тодорхой сорилтууд тулгарсан ч төслийн үр нөлөөг бүхэлд нь аваад үзвэл ТМБС-ын чанарыг сайжруулах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд илүү нийцүүлэх гэсэн урт хугацааны гол зорилтуудаа амжилттай урагшлуулжээ. МБСТ нь салбар цаашид хөгжих шинэ үндэс суурийг тавьж өгсөн. Төслөөс дэмжсэн бодлогын шинэчлэлийн нөлөөгөөр ТМБС-ын салбарт шинэ боломжууд нээгдэж Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд ур чадвартай ажилчдыг бэлтгэн нийлүүлэх гол салбар болсон. Мөн ЧСС болон хувийн хэвшлийн оролцоонд суурилсан орчин үеийн ТМБС-ын тогтолцоог бий болгож нэгдсэн стандарт, шинэ үзэл баримтлалыг танилцуулсан. Түүнчлэн төслөөс эхлүүлсэн ажлуудыг бусад донор байгууллагууд үргэлжлүүлэн салбарыг цаашид хөгжүүлэх суурь бололцоог бүрдүүлсэн. Эдгээр бүх үйл ажиллагаа тодорхой хүндрэл бэрхшээлтэй тулгарч, зарим нь МСК-аас хүлээсэн үр дүнд хүрээгүй боловч МБСТ улсын хэмжээнд салбар дахь шинэчлэлийг эхлүүлж, цаашид илүү орчин үеийн, ур чадвартай ажиллах хүчин бэлтгэх эргэлтийн цэг болж өгсөн юм. Зураг 1-д МБСТ-ийн логик загварыг үнэлгээний явцад судлан олж илрүүлсэн үр дүнгийн хамтаар үзүүлэв.

6. Дараагийн алхам

МСК хянаж нягталсны дараа энэхүү эцсийн тайланг МСК-ийн үнэлгээний каталогт олон нийтэд нээлттэй байршуулна. Түүнчлэн Вашингтон ДС хот дахь МСК-ийн оффис болон Улаанбаатар хотод оролцогч талуудад зориулан тайлангийн үр дүнг танилцуулах уулзалтыг зохион байгуулна. Тайлангийн хураангуйг монгол хэлнээ орчуулан гол үр дүнг оролцогч талуудтай хуваалцана. Цаашид үргэлжлүүлэн мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажил төлөвлөгдөөгүй болно.

Зураг 1. Төслийн логик загвар болон үр дүнгийн үнэлгээ *(зөвхөн судлагдсан зорилтууд)*